



Утга: Ховд аймагт ажилласан тайлан
Индекс: НВД/2011/01
Хаана: Дөргөн, Мянгад, Буянт, Дуут, Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Жаргалант сумд
Хэзээ: 2011 оны 5 дугаар сарын 15-наас 21-ний өдрүүд
Нэмэлт:

ТОЙМ

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал 2011.05.15-наас 21-ний өдрүүдэд өөрийн сонгогдсон тойрог Ховд аймгийн Дөргөн, Мянгад, Буянт, Дуут, Мөнххайрхан, Манхан, Зэрэг, Жаргалант сумдад ажиллаж, нийт 800 гаруй иргэд сонгогчидтой уулзаж, зарим төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын аж байдалтай танилцлаа.



Ховд аймаг - 2011.05.15-наас 21-ний өдрүүд.

Сум, орон нутгийн удирдлагаас УИХ-ын гишүүнд тулгамдаж буй асуудлуудаа танилцуулж, дэмжлэг хүссэн юм.

<i>№</i>	<i>Сум</i>	<i>Тулгамдаж буй асуудлууд</i>
1	Дөргөн сум	Соёлын төвийн сандал шинэчлэх асуудлыг шийдвэрлэх
2	Мянгад сум	Музейн үзвэрийг баяжуулахад 5 сая төгрөгний дэмжлэг үзүүлэх Сумын цэвэрлэх байгууламжийн асуудалд 500 сая төгрөг
3	Дуут сум	Сумын ЕБС-ийн халаалтын системийг шинэчлэхэд 10 сая төгрөгний асуудал Жи-Мобайлийн сүлжээнд холбогдох асуудал
4	Мөнххайрхан	Соёлын төвийн их засварын асуудалд 100 сая төгрөг шийдвэрлэж өгнө үү. Эмнэлгийн тоног төхөөрөмж, худаг гаргах асуудалд 10 сая төгрөг шийдвэрлэж өгнө үү.
5	Манхан	Соёл амралтын хүрээлэн байгуулах асуудалд 20 сая төгрөг Соёлын төвийн сандал шинэчлэх асуудалд 10 сая төгрөгний дэмжлэг үзүүлэх
6	Зэрэг сум	Бизнес инкубатор төв байгуулах
7	Жаргалант сум	Аймгийн төвийн гэрэлтүүлэгийн асуудалд 100 сая төгрөг шийдвэрлэж өгөх
8	Ховд аймаг	Орон нутгийн төсвийн алдагдлыг нөхөхөд Сангийн яамнаас 500-600 сая төгрөгийн зээл хөөцөлдөх асуудлыг шийдвэрлэж өгнө үү.
9	Чандмань	Соёлын төвийн хөгжим апартур авахад 5 сая төгрөг шийдвэрлэж өгнө үү.

Иргэд, сонгогчидоос УИХ-ын чуулганы үйл ажиллагаа, батлагдсан хууль, тогтоомж хэлэлцэж буй асуудлууд болон гишүүний үйл ажиллагаатай холбоотойгоор дараах багц асуудлыг хөндөж, хариулт авсан болно.

<i>№</i>	<i>Асуулт</i>	<i>Хариулт</i>
1	Бүсийн нэмэгдэл бий болгох асуудал	2 чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон УИХ-ын гишүүдээс өргөн мэдүүлсэн бүсийн нэмэгдэл олгох хуулийн төслүүдийн талаар танилцуулсан болно.
2	Аймгийн төвийг Улаанбаатар хоттой улсын чанартай хар замаар холбох асуудал	Төсөв, мөнгөний асуудал нь шийдэгдсэн. Түүнчлэн босоо тэнхлэгийн зам барихад төсөв, мөнгөний асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд одоо гүйцэтгэлийн асуудал үлдсэн талаар танилцуулсан.
3	Төрийн албаны тухай хуулийг өөрчлөх, төрийн албыг төрлийн алба болгож байгаа талаар хөндсөн	Эрх зүйн орчинг өөрчлөх ёстой бөгөөд ирэх жилийн сонгуулийн дараа яригдах болов уу гэсэн таамагтай байгаа талаар хариулт өгөв
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, эрх мэдлийг нэмэгдүүлэх	Энэ талаар тодорхой алхамууд хийгдэж байгаа бөгөөд энэ жилээс сум хөгжүүлэх сан тус бүрт 30-300 сая төгрөгийг байршил, хүн амын тоо, бизнес эрхлэх орчинг нь харгалзан олгохоор болсон.
5	Сонгуулийн тухай хуулийн шинэчлэл.	Зайлшгүй өөрчлөх ёстой бөгөөд пропорциональ хувилбарыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Өөрчилж чадвал олон сөрөг асуудлыг шийдэх боломжтой талаар дурдсан.
6	Ноолуурын ханш. Засгийн газраас 110 тэрбумын бонд гаргаж томоохон үйлдвэрүүдэд татаас болгож өгч байгаа нь зөв эсэх	Буруу. Шаталсан экспортын татварын тогтолцоотой байх, эх орондоо нэмүү өртөг үлдээх нь зөв зүйтэй талаар тайлбарласан болно.
7	Эрдэнэс МГЛ ХК, Эрдэнэс таван толгой ХК болон 536 ширхэг хувьцааг иргэн бүрт олгож байгаа талаар мэдээлэл өгнө үү	АН-ын УИХ-ын 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт иргэн бүртээ эх орны баялагаас хүртэх боломж олгохын тулд хувьцаа эзэмшүүлэх асуудлыг хөндөж байсан. Энэ нь эхлэл юм.
8	<ul style="list-style-type: none"> - Хойд сумдаас хур тунадас бага орж байна. Энэ нь Хятад, Казакстан улсууд үүл хуруулах технологи ашиглаж байгаатай холбоотой гэж үзэж байна. Арга хэмжээ авах хэрэгтэй - Байгаль экологи доройтож, бэлчээрийн асуудал хүндрэлтэй хэвээр байна - Боловсролын салбарыг чанаржуулж, багш нарыг аттестачилах хэрэгтэй - Багуудын Иргэдийн нийтийн хурлын эрх мэдлийг нэмэгдүүлмээр байна, түүнчлэн засаг даргыг сонгодог эсвэл томилдог аль нэг тогтолцоо нь хэрэгтэй байна - Малчдын амьдрал хүнд байна, тиймээс банкны өр зээлийг хөнгөлүүлмээр байна 	

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ихэвчлэн сөрөг мэдээ цацагдаж байна, мөн Солонгос кино гаргадгийг болиулмаар байна
- Их хуралдай хөдөлгөөний цаана Н.Энхбаяр байгаа гэж сонссон. Энэ ямар учиртай жагсаал цуглаан бэ
- УИХ-ын гишүүн Засгийн газрын сайдын албан тушаалыг хавсарч хийж байгаа нь буруу эсвэл боловсон хүчин дутуу байгаа хэрэг үү
- Хөшөөтийн уурхайн талаар нэг тийш нь эцэслэх хэрэгтэй байна. Нэг сайд нь хүрч ирээд хаадаг, нэг дарга нь хүрч ирээд нээдэг. Иймд тогтвортой ажиллуулах хэрэгтэй байна
- Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлого хүндрэлтэй байна. энэ асуудлыг анхаарч ажиллана уу.

зэрэг асуудлыг хөндөн, өөрсдийн санал бодлыг илэрхийлсэн юм.

Мөн Ардчилсан намаас зохион байгуулсан “Монгол хүн 2020 – Ховд” хэлэлцүүлэгт оролцож, энэ удаагийн тойрогтоо ажилласан байдлын талаар Ховд ТВ-д ярилцлага өгсөн болно.

Р.Амаржаргал 2008 онд Ховд аймгаас Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Парламентад гурвантаа сонгогдож буй тэрээр улсын төсөв, мөнгөний бодлого, макро эдийн засгийн орчин, аюулгүй байдал гадаад бодлого, батлан хамгаалах зэвсэгт хүчин, боловсрол, чөлөөт худалдаа зэрэг асуудлуудыг төрийн бодлогын түвшинд түлхүү анхаарч ажилладаг.

Ажлын алба

Монгол Улс, Улаанбаатар хот
Төрийн ордон – 211

Утас: 260127, Факс: 310127

И-мэйл: info@amarjargal.org

Цахим хуудас: www.amarjargal.org

Төсвийн байнгын хороо; Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо; Тусгай хяналтын дэд хорооны гишүүн,

Монгол-Их Британийн парламентын бүлгэм; Монгол-Люксембургийн парламентын бүлгэмийн дарга